



МОНГОЛЫН  
ХӨРӨНГИЙН БИРЖ

---

# ЖИЛИЙН ТАЙЛАН

---

2022

## АГУУЛГА

<b>1</b>	<b>ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ</b>	x4
<b>2</b>	<b>БИДНИЙ ТУХАЙ</b>	x6
	Монголын хөрөнгийн биржийн түүхэн товчоон	x8
<b>3</b>	<b>БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b>	x10
	Газруудын чиг үүрэг	x10
	Удирдлагын баг	x11
	Хүний нөөц	x12
<b>4</b>	<b>САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>	x13
<b>5</b>	<b>КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ</b>	x14
<b>6</b>	<b>ТУЗ-ийн ТАНИЛЦУУЛГА</b>	x15
	ТУЗ-ийн бүрэлдэхүүн, ур чадвар	x16

ИЙН БИРЖ  
EXCHANGE



	ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан	x17
	Хяналт мэдээллийн ил тод байдал	X18
	Гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг	X19
<b>7</b>	<b>ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД</b>	x20
<b>8</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ</b>	X29
<b>9</b>	<b>САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b>	x36
	Аудитын дүгнэлт	x38
	СТ4 тайлан /Аудитлагдсан/	X40

# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улс одоогоос 30 гаруй жилийн өмнө төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжих түүхэн үед өмч хувьчлалыг хэрэгжүүлэх зорилгоор Монголын Хөрөнгийн Биржийг анх байгуулж, улсын 475 үйлдвэрийн газар хувийн өмчид шилжин, нийт хүн амын 50 орчим хувь нь тэдгээрийн хувьцаа эзэмшигч болж байсан түүхтэй.

Үүнээс хойш хөрөнгийн зах зээлийн техник технологи, хууль эрх зүйн орчин олон улсын жишгийн дагуу шинэчлэгдэж, хөгжлийн үе шатуудыг туулан, өнөөдрийн байдлаар 2.4 сая үнэт цаасны данс эзэмшигч, 460 гаруй мянган хувьцаа эзэмшигчидтэй, 6.5 их наяд төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй болоод байна.

Сүүлийн жилүүдэд хувьцаа, бондын арилжаа идэвхжиж, шинээр болон нэмж үнэт цаас гаргах үйл ажиллагаа амжилттай явагдаж байгаагийн зэрэгцээ онцлог шинэ үйл явдлуудаар өрнүүн байна. Тухайлбал, 2017-2022 онуудад Монголын Хөрөнгийн Бирж дээр түүхэн дээд хэмжээний хувьцаа болон Засгийн газрын үнэт цаасны арилжаа явагдаж, хамгийн олон IPO бүртгэгдсэн. Тэр дундаа Монголын хамгийн том аж ахуйн нэгж болох

арилжааны банкууд болон даатгалын компаниудын үнэт цаас бүртгэгдэж, давхар бүртгэлтэй үнэт цаас гадаадын бирж болон Монголын Хөрөнгийн Бирж хооронд хөрвөн арилжигдах боломжтой болсон. Мөн манай зах зээл дээр цоо шинэ бүтээгдэхүүнүүд болох хамтын хөрөнгө оруулалтын сан, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нэвтэрсэн зэрэг томоохон ололт дэвшилттэй жилүүд байлаа.

Монголын хөрөнгийн биржийн хөгжлийг хөрөнгийн зах зээлийн индекс тооцоолол, судалгааны чиглэлээр дэлхийд тэргүүлэгч Их Британийн "FTSE Russell" Группээс үнэлж, Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг "Ажиглалтын жагсаалт"-аас "Хөгжиж буй" зах зээлийн зэрэглэлд ахиулахыг зөвшөөрсөн нь манай зах зээлийн оролцогч байгууллагууд, нийт ажилтнууд, үнэт цаас гаргагчид болон хөрөнгө оруулагчдын харилцан итгэлцэл, хамтын ажиллагааны үр дүн юм.

Бид тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн хариуцлагатай санхүүжилтийг дэмжиж, улс эх орныхоо бүтээн байгуулалт, үндэсний үйлдвэрлэл үйлчилгээг нэмэгдүүлэхэд бодит хувь нэмэр оруулан, үнэт цаас гаргагчдаа чадавхжуулж, зэрэгцэн хөгжиж, хамтран ажилласаар байх болно.



Гүйцэтгэх захирал  
**Х.АЛТАЙ**



**“Монголын хөрөнгийн биржийн хөгжлийг хөрөнгийн зах зээлийн индекс тооцоолол, судалгааны чиглэлээр дэлхийд тэргүүлэгч Их Британийн “FTSE Russell” Группээс үнэлж, Монголын Улсын хөрөнгийн зах зээлийг “Ажиглалтын жагсаалт”-аас “Хөгжиж буй” зах зээлийн зэрэглэлд ахиулахыг зөвшөөрсөн нь манай зах зээлийн оролцогч байгууллагууд, нийт ажилтнууд, үнэт цаас гаргагчид болон хөрөнгө оруулагчдын харилцан итгэлцэл, хамтын ажиллагааны үр дүн юм.”**

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д заасан 6 зүйлийн нэг болох “Төрийн бүтээмжийн сэргэлт”-ийг амжилттай хэрэгжүүлэхэд хөрөнгийн зах зээл, тэр дундаа Монголын Хөрөнгийн Бирж чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна. Тухайлбал, Улсын Их Хурлын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 16 тоот тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдаалах үндсэн чиглэл”, Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 244 дүгээр тогтоолын дагуу Монголын Хөрөнгийн Бирж нь төрийн өмчит бусад 25 компаниудыг түүхээс олон нийтэд нээлттэй компани болсноор Монголын санхүү, хөрөнгийн зах зээлийн цаашдын хөгжлийг эрчимжүүлэхэд түлхэц үзүүлж, дараагийн шинэ шатанд гарах томоохон алхмын эхлэл болно гэдэгт итгэлтэй байна.

Уул уурхайн биржийн тухай хууль 2022 оны 12 дугаар сард батлагдаж, МХБ хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12-р сарын 14-ний өдрийн 466 дугаар тогтоолоор батлагдсан “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Түүнчлэн “Экспортод гаргах нүүрсний арилжааг зохион байгуулах заавар”-ыг боловсруулан, арилжааны системийн бэлэн байдлыг хангаж, оролцогч байгууллагуудыг сургалт мэдээллээр ханган, экспортын нүүрсний цахим арилжааг зохион байгуулах эхлэлийг тавьлаа.

Бид хөрөнгө оруулагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн олон төрлийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгож, хувьцаа эзэмшигчдийнхээ үнэ цэнийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ зах зээлд оролцогчдын эрх ашгийг хүндлэн, харилцан ашигтай хамтран ажиллаж, зах зээлд манлайлагч байр сууриа хадгалж ажиллах болно.



## БИДНИЙ ТУХАЙ


Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн тvvхэн вeд Монгол Улсын Засгийн газрын 1991 оны нэгдүгээр сарын 18-ны өдрийн 22 тоот тогтоолоор улсын өмч хувьчлалын ажлыг эхлvvлж, vнэт цаасны зах зээлийг хөгжvvлэх зорилгоор Монголын хөрөнгийн биржийг vүсгэн байгуулсан.

Улмаар 1992 онд Засгийн газрын өмч хувьчлалын бодлогын хүрээнд нийт 475 улсын үйлдвэрийн газрыг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, тэдгээрийн 8.2 тэрбум төгрөгийн vнэлгээ бүхий 96.1 сая ширхэг хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулж иргэдэд хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр эзэмшүүлсэн. Үүний дүнд Монгол Улсын нийт хүн амын 52 орчим хувь буюу 1.2 сая хүн хувьцаа эзэмшигч болж байсан түүхтэй.


Энэхүү үйл явц нь Монгол Улсын эдийн засгийн бүтцийг өөрчилж, үр ашгийг дээшлүүлэх, зах зээлийн өрсөлдөөнийг бий болгох, эдийн засагт хувийн секторыг дэмжин хөгжүүлэх, өмч хувьчлалыг өргөн хүрээнд зохион байгуулах суурь нөхцлийг бүрдүүлсэн юм.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу Монголын хөрөнгийн бирж олон улсад нэр хүнд бүхий “Лондонгийн хөрөнгийн бирж” групптэй стратегийн түвшинд хамтран ажиллаж, хөрөнгийн зах зээлийн зохицуулалт, техник технологи, дэд бүтцийн хувьд хөгжлийн шинэ түвшинд хүрээд байна.

Үүгээр зогсохгүй Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг 2013 оноос хойш үе шаттай шинэчилсний үр дүнд хууль эрхзүйн орчин ч олон улсын жишигт хүрч хөгжлөө.



1991 он



2021 он

**Хууль эрх зүйн таатай орчин бий болсноор гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй, Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг компаниуд дотоодын хөрөнгийн биржид үнэт цаасны давхар бүртгэл хийлгэх боломж бүрдэж, 2018 онд Монголын хөрөнгийн бирж дээр анхны давхар бүртгэл хийсэн. Түүнчлэн хадгаламжийн бичиг, төлбөр тооцооны дараа төлбөрт систем, үнэт цаасны номинал болон бенефициар өмчлөл, кастодиан зэрэг бүтээгдэхүүн үйлчилгээ хөрөнгийн зах зээлд шинээр нэвтэрсэн.**

Мөн 2020 онд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг хөрөнгийн биржээр арилжаалах зохицуулалтыг шинээр бүрдүүлж, хувьцаат компаниудын үүргийн хэрэгжилтийг сайжруулж хариуцлагажуулах, төлбөр тооцооны дараа төлбөрт Т+2 горимыг амжилттай нэвтрүүлсэн.

Монголын хөрөнгийн бирж нь 1995 оны наймдугаар сарын 28-ны өдөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлснээс хойш 2021 оны эцсийн байдлаар нийт 4.75 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасны арилжааг зохион байгуулж, 30 жилийнхээ ойг түүхэн дээд амжилт, голлох үзүүлэлтүүдийн онцгой өсөлтөөр үдсэн юм. Түүнчлэн 2021 оны эхэнд Банкны тухай хууль шинэчлэгдэж, системийн нөлөө бүхий банкууд олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжин, гадаадын хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх, зах зээлд олон улсын стандартууд нэвтрүүлэх зорилгоор, дэлхийн ТОП-5 хөрөнгийн биржийн нэг Шанхайн хөрөнгийн биржтэй хамтын ажиллагааг эхлүүлсэн. 2022 онд Монголын Хөрөнгийн Бирж төдийгүй хөрөнгийн зах зээлд онцгой нөлөө үзүүлэх хэд хэдэн үйл явц өрнөсөн.

Тухайлбал, олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгааны чиглэлээр тэргүүлэгч "FTSE Russell" группээс 2022 оны 9-р сарын 29-ний өдөр Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг FTSE Russell-ийн "Хөгжиж буй" (Frontier Market) зах зээлийн зэрэглэлийн шалгуурыг бүрэн хангасан тул 2023 оны 9 дүгээр сараас эхлэн тус ангилалд оруулахыг зөвшөөрсөн юм. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд, засаглал сайжруулах чиглэлд төрийн өмчит компаниудаас нэн тэргүүнд Монголын Хөрөнгийн Биржийг олон нийтэд нээлттэй компани болгох шийдвэрийг гаргаж, "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК нь нийт хувьцааныхаа 34 хувийг олон нийтэд санал болгон, олон нийтийн өмчийн оролцоотой компани боллоо.

Ингэснээр "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц шинэчлэгдэж, олон нийтийн хараа хяналт, ашигт ажиллагаа, компанийн засаглал, мэдээллийн ил тод байдал сайжирч, гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчдын сонирхлыг дотоодын зах зээлд татах

боломжийг нээх ХӨГЖЛИЙН ШИНЭ ТҮҮХИЙГ эхлүүлсэн.

Мөн УИХ, Засгийн газраас 2020-2022 онд хөрөнгийн зах зээлийг дэмжсэн томоохон бодлогуудыг гаргасны нэг нь Монгол Улсын банк, санхүүгийн салбар, тэр дундаа системийн таван банкиг олон нийтийн хувьцаат компани болгох, "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл"-ийг Засгийн газрын 244 дүгээр тогтоолоор батлан, хуулийн этгээдийн жагсаалтыг гаргасан.

2022 оны 9-р сарын 30-нд Төрийн банк, 2022 оны 11-р сарын 23-ны өдөр Голомт банк олон нийтийн хувьцаат компани болох үйл явцыг албан ёсоор эхлүүлж, Монгол Улсын Хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжаагаар анх удаа хувьцаагаа нийтэд санал болгоод байна.

2022 оны 12 дугаар сард Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас боловсруулсан "Экспортын нүүрсийг цахимаар нээлттэй арилжих журам"-ыг баталсан юм. Энэхүү журмын дагуу "Уул уурхайн биржийн тухай хууль" батлагдах хүртэл 2023 оны нэгдүгээр сарын 1-нээс Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан экспортын нүүрсийг нээлттэй арилжиж эхлэх боломж бүрдээд байна.

	2021	2022
ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	₮5.97 их наяд	₮6.89 их наяд
ТОП-20 ИНДЕКС	44,411.60	37,565.55
БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИЙН ТОО	179	183
ӨДРИЙН ДУНДАЖ АРИЛЖАА	₮5.7 тэрбум	₮2.4 тэрбум



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ТҮҮХЭН ТОВЧООН

1991.01.18

Монголын Хөрөнгийн Бирж байгуулагдав.

1992.02.07

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа эхлэв.

1994.09.26

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль батлагдав.

2011.04.07

Лондонгийн хөрөнгийн бирж групптэй стратегийн түншлэлийн "Ажлын мастер гэрээ" байгуулав.

2005.05.25

Анхны IPO амжилттай хийгдэв.

2001.06.08

Анхны компанийн бондыг арилжаалав.

2012.06.08

Олон улсад нэр хүнд бүхий "Миллениум Ай Ти" цогц системийг зах зээлд нэвтрүүлээ.

2014.12.02

Монголын хөрөнгийн бирж өөрийгөө зохицуулах байгууллага боллоо.

2015.12.22

Төрийн өмчийн хувьчлалыг хөрөнгийн биржээр нээлттэй явуулав.

2021.01.15

Давхар бүртгэлтэй үнэт цаасны бирж хоорондын хөрвүүлэлт амжилттай хийгдлээ.

2021.01.15

Монголын хөрөнгийн бирж ханшийн лавлагааны үйлчилгээг цахимжууллаа.

2021.01.18

Монголын хөрөнгийн бирж хөрөнгийн зах зээлийн түүхэн үзвэрийн танхимтай боллоо.

2021.06.30

Шанхайн хөрөнгийн биржтэй хамтын ажиллагаа эхлүүлээ

2021.09.30

Монголын хөрөнгийн зах зээл FTSE RUSSELL-ийн "хөгжиж буй зах зээлийн ажиглалтын жагсаалт"-нд албан ёсоор орлоо

2021.12.01

Богд банк ХК банкны салбарын реформын хүрээнд хувьцаат компани болж буй анхны банк боллоо

2022.12.30

"Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК үнэт цаасаа олон нийтэд санал болгон Нээлттэй хөрөнгийн бирж болов.

**1994.11.14**

Үнэт Цаасны Хороо байгуулагдав.

**1995.07.08**

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо байгуулагдав.

**1995.08.28**

Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэв.

**2001.02.09**

TOP-20 индекс тооцож эхлэв.

**1996.10.25**

Засгийн газрын бондыг хөрөнгийн биржээр арилжаалж эхлэв.

**1995.08.28**

TOP-75 индекс тооцож эхлэв.

**2017**

859.2 тэрбум төгрөгийн арилжаа хийж, түүхэн амжилт тогтоов.

**2018.02.08**

MSE A болон MSE B индексүүдийг тооцож эхлэв.

**2018.04.04**

Анхны гадаадын үнэт цаасыг давхар бүртгэв.

**2020.12.28**

Анхны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэв.

**2020.08.24**

Анхны хаалттай хамтын хөрөнгө оруулалтын сан бүртгэгдэв.

**2020.03.31**

Төлбөр тооцооны T+2 горимд шилжив.

**2022.05.10**

Бүртгэлтэй компаниуд сайн дурын үндсэн дээр ESG буюу Байгаль Орчин Нийгэм Засаглалын тайлагналын стандартыг мөрдөхөөр болов.

**2022.04.29**

Монгол Улсын Их Хурлаас "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл"-ийг батлав

**2022.09.14**

Банкны тухай хуулийн дагуу системийн нөлөө бүхий банк болох Төрийн банк МХБ дээр бүртгэгдэв.

**2022.12.14**

Экспортод гаргах нүүрсний цахим арилжааг зохион байгуулах эрхтэй болов.

**2022.12.01**

Хамгийн олон буюу 21,821 хөрөнгө оруулагч "Голомт банк" ХК-ийн IPO-д оролцов.

**2022.09.29**

"Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг FTSE Russell-н Frontier market ангилалд албан ёсоор оруулахыг зөвшөөрөв.



# БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



## ГАЗРУУДЫН ЧИГ ҮҮРЭГ

Захиргаа, санхүүгийн газар нь компанийн дотоод үйл ажиллагаа, зохион байгуулалт, санхүүгийн үйл ажиллагааг бүхэлд нь хариуцаж ажиллах ба чиг үүргээрээ Захиргааны алба, Санхүүгийн алба гэсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулдаг.

Үйл ажиллагааны газар нь арилжааны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, бизнесийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллах, хөрөнгийн биржийн мэдээллийн технологийн дэд бүтцийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих үндсэн чиг үүрэгтэйгээр Арилжааны алба, Мэдээллийн технологийн алба гэсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулдаг.

Хяналт, зохицуулалтын газар нь бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой үнэт цаас гаргагч байгууллагууд, гишүүн үнэт цаасны компани, арилжааны хяналт, хөрөнгийн зах зээлийн эрсдэлийн үнэлгээ хийх чиг үүрэгтэйгээр Хяналт шинжилгээний алба, Бүртгэлийн алба гэсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулж байна.

**Бизнес, хөгжлийн газар** нь Зах зээлийн хөгжлийн алба болон Маркетинг, олон нийттэй харилцах алба гэсэн зохион байгуулалтаар үйл ажиллагаа явуулж, Биржийн үйл ажиллагаа явуулж буй салбарын төлөв байдал, олон улсын чиг хандлагад тулгуурлан Биржийн стратеги, бизнес төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтийг хангаж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж ажилладаг зохион байгуулалтын бүтэц юм.

## УДИРДЛАГЫН БАГ



### Х.АЛТАЙ

Гүйцэтгэх захирал

- 2016 оноос эхлэн Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал

Боловсрол:

- 2018-2020 Бизнесийн удирдлага, Магистр СЭЗДС, Монгол Улс
- 1999-2004 Эрх зүйч, Бакалавр, МУИС-ийн Хууль зүйн сургууль Монгол Улс

Ажлын туршлага:

- 2015-2016 “БИ БИ энержи” ХХК-ийн Монгол Улс дахь төлөөлөгч
- 2010-2012 МУ-ын ЗГ, Ерөнхий сайдын Ажлын алба, Ерөнхий сайдын зөвлөх
- 2011-2014 Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал
- 2010-2011 Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн Тэргүүн дэд захирал
- 2004-2007 “Боро гоулд ХХК”-ийн Засгийн газартай харилцах алба
- 2003-2007 МУ-ын ЗГ, Ерөнхий сайдын Ажлын алба, Ерөнхий сайдын шадар туслах



### Т.ХАШ-ЭРДЭНЭ

Бизнес хөгжлийн газрын захирал

- 2022 оноос эхлэн Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн Бизнес хөгжлийн газрын захирал

Боловсрол:

- 2001-2005 Олон улсын ЭЗ-ийн харилцаа, Бакалавр, РУДН ОХУ
- 2019-2023 Эрх зүйч, Бакалавр, МУИС-ийн Хууль зүйн сургууль Монгол Улс

Ажлын туршлага:

- 2021-2022 Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн Дэд захирал
- 2021 ЗГХЭГ, МУ-ын Ерөнхий сайдын Эдийн засгийн бодлого хариуцсан зөвлөх
- 2018-2021 ЗГХЭГ, МУ-ын Ерөнхий сайдын дэргэдэх Эдийн засгийн бодлогын зөвлөлийн Ажлын албаны дарга
- 2017-2018 ЗГХЭГ, МУ-ын Ерөнхий сайдын Олон нийттэй харилцах бодлого хариуцсан Орон тооны бус зөвлөх
- 2012-2017 “Монгол Медиа Корпораци” ХХК-ийн Газрын захирал



### А.МӨНХБАЯСГАЛАН

Хяналт, зохицуулалтын газрын захирал

- 2017 Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн Хяналт, зохицуулалтын газрын захирал

Боловсрол:

- 1994-1999 Бизнесийн удирдлага Бакалавр, Парисын 9 дүгээр их сургууль Франц улс
- 1999-2000 Төрийн удирдлага, Магистр Парисын 9 дүгээр их сургууль Франц улс

Ажлын туршлага:

- 2015-2017 Сангийн яамын газрын дарга
- 2006-2015 ХХБ ХХК-ийн Газрын захирал
- 2005-2006 Үйлдвэрлэл, худалдааны яамны мэргэжилтэн
- 2004-2005 СЭЗДС-ийн Бизнесийн удирдлагын тэнхимийн Бизнесийн удирдлагын багш



### Н.ДӨЛ-ЭРДЭНЭ

Захиргаа, санхүүгийн газрын захирал

- 2017 оноос эхлэн Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн Захиргаа, санхүүгийн газрын захирал

Боловсрол:

- 2012-2019 Бизнесийн удирдлага, Докторант, Хятадын Соёлын Их Сургууль, Тайвань
- 2002-2004 Бизнесийн удирдлага, Магистр, СЭЗДС, Монгол Улс
- 1995-1999 Санхүү-Эдийн засагч, Мэдээлэл зүйч мэргэжлээр Эдийн засгийн ухааны бакалавр, МУИС-ЭЗС Монгол Улс

Ажлын туршлага:

- 2014-2016 Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга, Дотоод аудитор
- 2011-2012 Эм Си Эс холдинг ХХК-ийн санхүүгийн менежер
- 2002-2011 Чингис хаан банк ХХК-ийн Хөрөнгө зохицуулат, эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал
- 2001-2002 Тээвэр хөгжлийн банк ХХК-ийн Эдийн засагч
- 1999-2001 МУИС-Лицей сургуулийн компьютерийн багш

### И.ЖАВХЛАН

Үйл ажиллагааны газрын захирал

- 2020 оноос эхлэн Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн Үйл ажиллагааны газрын захирал

Боловсрол:

- 2016 Санхүүгийн удирдлага, магистр Мельбурн Их сургууль, Австрали улс
- 2005-2009 Олон улсын эдийн засгийн харилцаа Бакалавр, МУИС-ОУХС, Монгол Улс


Ажлын туршлага:

- 2017-2020 Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн Зах зээл хөгжийн албаны Ахлах мэргэжилтэн
- 2011-2015 Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн Бүртгэлийн албаны Ахлах мэргэжилтэн



## ХҮНИЙ НӨӨЦ

МХБ-ийн "Хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-ийг орчин үеийн хүний нөөцийн удирдлагын чиг хандлага, байгууллагын ажилтнуудын зан төлөвт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Аливаа байгууллагын үндсэн үүргийн хувиар ажилтнуудын боловсрол, мэдлэг чадварыг тасралтгүй хөгжүүлэх сургалт зохион байгуулж, мөн нэмэлт ур чадварыг бий болгох чиглэлийг дэмжин ажиллав. Хүний нөөцийн хөдөлгөөн, хуваарилалтыг амжилттай хэрэгжүүлснээр 2022 оны эцэст нийт 52 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.




МОНГОЛЫН МЭРГЭШСЭН  
НЯГТЛАН БОДОГЧДЫН  
ИНСТИТУТ

**2**

Мэргэшсэн нягтлан бодогч



CFA Institute

**1** **3**

Олон улсын итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээч

Олон улсын итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээч цол горилогч




CISCO  
CERTIFIED  
CCNA

**1**


Олон улсын мэргэшсэн компьютерын сүлжээний инженер

## 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


НИЙТ ОРЛОГО (сая төгрөг)




ХУРААМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС  
(сая төгрөг)




НИЙТ ЗАРДАЛ (сая төгрөг)




ЦАЛИНГИЙН ЗАРДАЛ (сая төгрөг)



АРИЛЖААНЫ ШИМТГЭЛ (сая төгрөг)




ТӨСӨВТ ТӨЛСӨН ТАТВАР,  
ШИМТГЭЛ (сая төгрөг)



МIТ СИСТЕМИЙН АШИГЛАЛТ,  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР (сая төгрөг)



ЦЭВЭР АШИГ (сая төгрөг)



# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

## ТУЗ-ийн үүрэг

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь МХБ-ийн үйл ажиллагааны үр дүнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээдэг.

ТУЗ гүйцэтгэх захирлын ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх, томилох, дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах зэрэг үүрэгтэй. Компанийн 2019-2021 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний хугацаа дуусч, дараагийн дунд хугацааны төлөвлөлт буюу 2022-2024 онд хэрэгжүүлэх стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, удирдамж, зөвлөмжөөр хангаж ажиллалаа. Тайлант хугацаанд МХБ-ийн гүйцэтгэх удирдлагын баг үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтоо хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих зорилгоор тогтмол хуралдсан байна. ТУЗ-ийн үүргийг “Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн дүрэм” болон “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-д тодорхой заасан байдаг.

## ТУЗ-ийн хороод

МХБ нь ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий байнгын 3 хороотой ба эдгээр хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор санал дүгнэлт гаргах үндсэн зорилготой. Хороодын үйл ажиллагааг “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-аар зохицуулдаг.

ТУЗ нь дараах байнгын хороодтой:

- Нэр дэвшүүлэх хороо;
- Аудитын хороо;
- Цалин, урамшууллын хороо.

ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болно. Компанийн тухай хуульд ТУЗ-ийн хараат бус гишүүн нь аудитын хороонд ажиллахаар заасан байдаг.

## Аудитын хорооны бүрэлдэхүүн

А. Анар	Хорооны дарга
Д. Баянзул	Гишүүн
А. Батпүрэв	Гишүүн

## Цалин, урамшууллын хорооны бүрэлдэхүүн

Б. Наранчимэг	Хорооны дарга
Р. Гандиймаа	Гишүүн
А. Анар	Гишүүн

## Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн

Ч. Дондогмаа	Хорооны дарга
Р. Гандиймаа	Гишүүн
А. Батпүрэв	Гишүүн

## ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, шинэчлэх

ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнийг бүрдүүлэхэд хараат бус үнэлгээ дүнэлт гаргах зорилгоор нэр дэвшүүлэх хороог байгуулдаг. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүдийн ур чадвар, туршлагыг хянан шалгаж, гишүүдийн ур чадвар МХБ-ийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг үйл ажиллагааг хангаж ажиллахад зохистой эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгдөг. Энэхүү үнэлэлт, дүгнэлтэд үндэслэн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд шинээр оруулах гишүүнийг нэр дэвшүүлдэг. Гишүүдийг томилохоос өмнө Компанийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм журмын дагуу боловсрол, ур чадвар, өмнөх ажил эрхлэлтийн түүх, их хэмжээний зээлийн өртэй эсэх, гэмт хэрэгт холбогдсон эсэх зэрэг асуудлаар цогц судалгаа, шинжилгээг хийдэг.

## Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн

Нэр дэвшүүлэх хороо 2022 онд 2 удаа хуралдаж Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Засгийн газрын Ахлах референт Ч.Дондогмаа нарыг ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэн Хувьцаа эзэмшигчдэд танилцуулсан бөгөөд ТУЗ шинэ 2 гишүүний бодлого, стратеги төлөвлөлт, хууль эрх зүйн талаарх ажлын туршлага, ур чадвар нь ТУЗ-ийн одоогийн бүтэц,

бүрэлдэхүүний ур чадвар, туршлагыг улам чанаржуулах, үнэ цэнэ нэмэх ач холбогдолтой гэж үзсэн байна.

## ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, улируулан сонгох

ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар 1 жилийн хугацаатай сонгодог бөгөөд гишүүнийг улируулан сонгож болно. Чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан ТУЗ-ийн гишүүнийг орлох гишүүнийг нөхөн сонгох хүртэл ТУЗ түр томилж болдог. 2022 онд гишүүн Д.Баянзул, Д.Энхбаатар, М.Санжаадорж, Л.Наранчимэг, А.Батпүрэв, Р.Гандиймаа, А.Анар нар улиран сонгогдсон бол С.Энхзориг, Б.Сүх-Очир нарыг чөлөөлж, С.Тулга, Ч.Дондогмаа нарыг шинээр томилсон байна.

## ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ТУЗ үйл ажиллагаагаа хэвийн явуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах зорилгоор ТУЗ-д шууд хариуцлага хүлээх нарийн бичгийн даргыг томилох үүрэгтэй. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх шаардлагатай бөгөөд ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилдог.

2022 онд уг албан тушаалыг эрхэлж байгаа этгээдэд өөрчлөлт орж, 2022 оны 11 дүгээр сард шинээр томилсон ба холбогдох гэрчилгээг авсан байна.



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА, БҮТЭЦ, УР ЧАДВАР

	НЭР	АЛБАН ТУШААЛ	Томилогдсон огноо
1	С.ТУЛГА ТУЗ-ийн дарга Төрийн удирдлагын магистр	Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга	2022.11.02
2	Д.БАЯНЗУЛ Ердийн гишүүн Олон улсын эдийн засгийн магистр	Монголбанкны Эрсдэлийн удирдлагын албаны захирал	2018.03.26
3	Д.ЭНХБААТАР Ердийн гишүүн Бизнесийн удирдлагын магистр	Санхүүгийн зохицуулах хорооны Захиргаа удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	2021.09.10
4	Ч.ДОНДОГМАА Ердийн гишүүн Хууль зүйн магистр	Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Засгийн газрын ахлах референт	2022.12.01
5	М.САНЖААДОРЖ Ердийн гишүүн Төрийн удирдлагын магистр	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	2019.07.23
6	Б.НАРАНЧИМЭГ Ердийн гишүүн Эдийн засгийн ухааны магистр	Сангийн яамны Төрийн сангийн газрын Төлбөр тооцооны хэлтсийн дарга	2021.09.10
7	А. БАТПҮРЭВ Хараат бус гишүүн Эдийн засгийн магистр	"Скайтел" ХХК-ийн Стратегийн удирдлага, төлөвлөлтийн албаны захирал	2018.07.04
8	Р.ГАНДИЙМАА Хараат бус гишүүн Сэтгүүлзүйн магистр	"МҮОНРТ"-ийн Монголын мэдээ сувгийн захирал	2018.07.04
9	А.АНАР Хараат бус гишүүн Эдийн засгийн ухааны бакалавр	"МИК ОССК" ХХК-ийн үйл ажиллагаа хариуцсан захирал	2018.07.04



## ТУЗ-ийн гишүүдийн ур чадвар, туршлага

Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах гишүүдийн хамтын ур чадварт байж болох ур чадварын дутуу орон зайг илрүүлэх, гишүүдийн ур чадвар, ажлын туршлагыг үнэлэх зорилгоор дээрх хүснэгтээр харуулсан матрицыг хэрэглэдэг. Гишүүдийн салбарын мэдлэг туршлага, мэргэжлийн ур чадвар болон хүйсийн тэнцвэртэй харьцааг хадгалах нь МХБ-д тулгарч байгаа асуудал, сорилтуудыг оновчтойгоор шийдвэрлэх, гүйцэтгэх захирал болоод удирдлагын багийн бусад гишүүд үйл ажиллагааны стратеги төлөвлөлтийг хэрхэн хэрэгжүүлж байгаад бодит үнэлгээ, дүгнэлт өгөхөд чухал үүрэгтэй.

ТУЗ өөрийн бүтэц, бүрэлдэхүүнийг зохих түвшинд байна гэж үзсэн бөгөөд компанийн сайн засаглалын зарчмын дагуу ур чадвар, бүтэц, бүрэлдэхүүний тэнцвэртэй байдлыг ханган ажиллаж ирсэн

## ТУЗ-ийн ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН - хурал, сургалт

### ГИШҮҮД ТУЗ-ИЙН ХУРАЛД ОРОЛЦСОН БАЙДАЛ

ТУЗ-ийн гишүүд компанийн засаглалын сургалтад хамрагдаж, сургалтын гэрчилгээ авсан байх шаардлагатай бөгөөд энэхүү шаардлагын дагуу 2022 онд шинээр томилогдсон ТУЗ-ийн гишүүд болох С.Тулга, Ч.Дондогмаа нар компанийн засаглалын сургалтад хамрагдан гэрчилгээг авсан байна.

ТУЗ нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн дүрэм, “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын дагуу үйл ажиллагаа явуулдаг.

ТУЗ-ийн үйл ажиллагааны гол хэлбэр нь ТУЗ-ийн хурал бөгөөд хурлын шийдвэрийг тогтоолоор баталгаажуулж гаргадаг. 2022 онд ТУЗ нийт 10 удаа

хуралдсан бөгөөд үүнээс 4 нь албан бус хурал байв. ТУЗ-ийн хурлаар нийт 50 гаруй асуудал хэлэлцэн, компанийн үйл ажиллагаа болон ТУЗ-ийн дотоод ажилтай холбоотой 40 тогтоол гаргаж, 10 тэмдэглэлээр гүйцэтгэх удирдлагад үүрэг, даалгавар өгч ажилласан.

ТУЗ-ийн бүх хурал Улаанбаатар хотод Сангийн яам болон МХБ-ийн хурлын танхимд зохион байгуулагдсан.

## Цалин, урамшуулал

ТУЗ-ийн гишүүдэд сар бүр тогтмол цалин хөлс олгодог. МХБ-ийн ТУЗ-ийн ердийн гишүүд нь Сангийн яаманд ажилладаг төрийн албан хаагч нар байдаг бөгөөд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа төрийн албан хаагч цалин хөлснөөс бусад шан харамж, урамшуулал авахыг хориглодог тул ердийн гишүүний цалин, урамшуулал нь зөвхөн цалин хөлснөөс бүрддэг.

ТУЗ-ийн гишүүний цалин хөлсний хэмжээг Монгол улсын Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын дагуу тогтоодог бөгөөд гишүүдийн цалин хөлсний дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байдаг.

МХБ-ийн хараат бус гишүүдийн цалин урамшууллын бүтэц ердийн гишүүдийн цалин урамшууллын бүтэцтэй адил байдаг. ТУЗ-ийн гишүүнд зуучлалын хөлс, зөвлөх үйлчилгээний хөлс зэрэг бусад төлбөр, нөхөн олговор олгодоггүй.

### Ашиг сонирхлын зөрчил

Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Мэдээллийн ил тод байдлын журам”-ын дагуу гишүүд эзэмшиж байгаа үнэт цаасны талаарх мэдээллийг ил тод танилцуулах үүрэгтэй. Гишүүн ТУЗ-ийн хэлэлцэх асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй тохиолдолд тухайн асуудлыг хэлэлцэх болон санал өгөхөд оролцдоггүй.

### Гишүүдийн бие даасан байдал

ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнд хараат бус гишүүн олон байх нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт эерэг нөлөөтэй. МХБ-ийн ТУЗ нь “Компанийн тухай хууль”-ийн 75.4 дэх заалтын дагуу хараат бус 3 гишүүнтэй байна. Нэр дэвшүүлэх хороо шинэ гишүүний танилцуулга, холбогдох баримт материалыг “Авилгатай тэмцэх газар”-т /АТГ/ хүргүүлэн гишүүний бие даасан байдлыг тодорхойлуулдаг. АТГ нь гишүүд хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийн төлөө ажиллахад, мөн бие даасан үйл ажиллагаа явуулахад материаллагаар нөлөөлж болох ашиг сонирхлын зөрчилтэй эсэхийг хянаж шалгадаг.

### Мэдээллийн ил тод байдал

МХБ нь үнэт цаасны 3 дугаар ангилалд бүртгэлтэй компани тул Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Мэдээллийн ил тод байдлын журам”-ын дагуу жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланг бэлтгэн нийтэд толилуулах үүрэгтэй. “Компанийн тухай хууль” болон “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн дагуу хувьцаа эзэмшигч, зах зээлд оролцогч байгууллагууд болон иргэдийг жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайлан, үйл ажиллагааны тойм танилцуулга, сар тутмын гол үйл явдлуудын эмхэтгэл зэрэг үйл ажиллагааны мэдээллээс гадна хөрөнгийн зах зээлийн өдөр тутмын үйл явдлын мэдээ, мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан Монгол, Англи хэл дээр тогтмол хүргэдэг бөгөөд олон нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг тухайлчлан зарим этгээдэд мэдээлдэггүй.







### Гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг

МХБ-ийн гүйцэтгэх захирлын үүрэг хариуцлагын талаар Компанийн дүрэмд тодорхой заасан байдаг. Гүйцэтгэх захирал нь МХБ-ийн өдөр тутмын удирдлага, үйл ажиллагааг хариуцаж, ТУЗ-өөс баталсан үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй. ТУЗ-ийн 2017 оны 10 сарын 02-ны өдөр байгуулсан “Хөлсөөр ажиллах гэрээ”-г сунгахаар шийдвэрлэсний дагуу тайлант хугацаанд гүйцэтгэх захирлаар Х.Алтай ажилласан. 2022 онд МХБ-ийн 2022-2024 оны дунд хугацааны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, 2022 оны бизнес төлөвлөгөө, бүтэц зохион байгуулалт, холбогдох дүрэм журмыг боловсруулж ажилласан.

### Гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүнг үнэлэх

Гүйцэтгэх захирал Х.Алтай ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд МХБ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг. ТУЗ гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг жил тутам үнэлэн дүгнэлт гаргадаг. Төрийн өмчийн хорооноос баталсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг тэнцвэржүүлсэн үнэлгээний аргаар дүгнэх, урамшуулал олгох журам”-ын дагуу Гүйцэтгэх захирлын ажлын үр дүнг үнэлэхдээ үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний гүйцэтгэл, эрсдэлийг удирдсан байдал, санхүүгийн зорилго, зорилтын биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт зэргийг төлөвлөлттэй харьцуулдаг. 2022 онд санхүүгийн зорилго, зорилтод хамаарагдах үзүүлэлт 70% гүйцэтгэлтэй байсан бол үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 90% байв.



# ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

# 2022



МОНГОЛЫН  
ХӨРӨНГИЙН БИРЖ

## “IPO MONGOLIA 2022” ФОРУМ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр “IPO Mongolia 2022” форум нь “Хүртээмжтэй хөрөнгийн зах зээл” сэдвийн доор амжилттай зохион байгуулагдлаа. “IPO Mongolia 2022” форумд төр, хувийн хэвшил, олон улсын хөгжлийн байгууллагууд, ТОП 100 аж ахуйн нэгжийг төлөөлөл, санхүүгийн салбарын оролцогчид болон хөрөнгийн зах зээлийн зохицуулагч байгууллагуудын төлөөллүүд оролцсон.

Чуулга уулзалтаар хөрөнгийн зах зээл дээрх бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх, төрийн өмчит компаниудыг биржээр дамжуулан нээлттэй хувьцаат компани болгох ач холбогдол, IPO хийхэд компанийн үнэлгээний үр өгөөж, олон улсын стандартууд, гадаадын хөрөнгө оруулалт татах боломж, банкны салбарын реформ, бондын зах зээл болон тогтвортой хөрөнгийн зах зээл зэрэг өргөн сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийн хурдыг нэмэгдүүлэх гарц, шийдлийг хайсан юм.

## МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК, САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬТАЙ “ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ” БАЙГУУЛЛАА

“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК болон Санхүү, эдийн засгийн их сургуулийн удирдлагууд 2022 онд дунд хугацааны “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгууллаа.

Уг санамж бичгийн хүрээнд “Монголын хөрөнгийн зах зээлийн боловсрол” үндэсний хэмжээний цогц хөтөлбөрийг боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд энэхүү хөтөлбөр нь санхүү, хөрөнгийн зах зээлийн салбарын хүний нөөцийг чадавхжуулах, судалгаа, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хөрөнгийн зах зээлийн талаарх иргэдийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэхэд чиглэх юм. Тэр дундаа арилжаанд хэрхэн оролцох, хувьцааны үнийн хэлбэлзэлд хэрхэн анализ хийх талаар сургалтуудыг иргэд, олон нийтэд зориулан тогтмол зохион байгуулахаараа онцлог.



## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНД НОГДУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСИЙГ 50-75 ХУВИАР БУУРУУЛЛАА

Хөрөнгийн зах зээлд мэргэжлийн буюу байгууллагын хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлж, зах зээлийн хөгжлийг дэмжих үүднээс Монголын хөрөнгийн бирж хөрөнгө оруулалтын сангийн шимтгэл хураамжийн хэмжээнд өөрчлөлт орууллаа. Тодруулбал, хөрөнгө оруулалтын сангууд МХБ-д нэгж эрхээ бүртгүүлж, олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэхдээ төлдөг байсан үйлчилгээний хөлс нэг хувь байсныг 0.25-0.5 хувь (25-150 сая төгрөг) болгон 50-75 хувиар, хөрөнгө оруулалтын сангийн жилийн үйлчилгээний хөлс 0.1 хувь байсныг 0.05 хувь (<50 сая төгрөг) болгож, 50 хувиар тус тус бууруулав.



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ХУРААМЖ БУУРЛАА

Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, уг өөрчлөлтийн хүрээнд компанийн хувьцаа бүртгэх үйлчилгээний хөлсийг 10-40 хувиар, компанийн бонд бүртгэх үйлчилгээний хөлсийг 36 хүртэлх хувиар буурууллаа.

## АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД ХУВЬЦАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХ ГАРГАГЧИЙН ТӨЛӨХ АРИЛЖААНЫ ШИМТГЭЛИЙГ ТЭГЛЭЛЭЭ

Монголын хөрөнгийн бирж анхдагч зах зээлд хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх гаргагчийн төлөх арилжааны шимтгэлийг 100 хувь чөлөөллөө.

Ингэснээр хөрөнгийн биржээр дамжуулан хувьцаагаа олон нийтэд санал болгох нээлттэй хувьцаат компаниудын тоо өсөж, хөрөнгийн зах зээл өргөжин тэлэх боломж бүрдэж байна.

## МХБ-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Х.АЛТАЙ КИРГИЗИЙН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮН ЭЛЕБАЕВ НУРБЕК БЕККУЛОВИЧТОЙ УУЛЗЛАА

Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал Х.Алтай Киргизийн хөрөнгийн биржийн ТУЗ-ийн гишүүн, Бодлого төлөвлөлт, засаглалын хорооны дарга Элебаев Нурбек Беккуловичийг хүлээн авч уулзлаа.

Уулзалтаар Монгол, Киргизийн хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагын талаар мэдээлэл солилцлоо.

Киргизийн хөрөнгийн биржийн тухайд, төр-хувийн өмчийн хосолмол бүтэцтэй бөгөөд Истанбулын хөрөнгийн бирж, Казахстаны хөрөнгийн бирж, Азийн хөрөнгө оруулалтын компани болон Киргизстан банк зэрэг гадаад, дотоодын 17 хувьцаа эзэмшигчтэй байна.





## БУДАПЕШТИЙН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА МИХАЛИ ПАТАЙ МХБ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА

Монголын хөрөнгийн биржийн удирдлагууд 2022-07-18 өдөр Унгарын төв банкны Дэд ерөнхийлөгч, Мөнгөний бодлогын зөвлөлийн гишүүн, Будапештын хөрөнгийн биржийн Удирдах зөвлөлийн дарга, Доктор Михали Патайг хүлээн авч уулзлаа.

Уулзалтаар талууд хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага, хамтран ажиллах боломжуудын талаар санал солилцсон юм.

Унгар улс дахь хөрөнгийн зах зээлийн үүсэл хөгжил 1860-аад оноос эхлэлтэй бөгөөд тус улсад 1990 онд Үнэт цаасны тухай хууль батлагдаж, орчин цагийн хөрөнгийн зах зээлийн үндэс суурь тавигдан, Будапештын хөрөнгийн бирж өөрчлөн байгуулагджээ.

Ноён Михали Патай "Хоёр улсын хөрөнгийн зах зээлийн орчин үеийн түүхэн замналд ижил төстэй зүйл цөөнгүй байна" гээд хойшид хамтран ажиллаж, туршлага солилцоход нээлттэй гэдгээ илэрхийллээ.



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ СИНГАПУРЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАНА



Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал Х.Алтай 2022 оны 8-р сарын 30-ны өдөр Сингапурын хамтын ажиллагааны байгууллагын Хойд Ази болон Ойрх Дорнодын бүс нутаг хариуцсан газрын захирал, ноён Тан По Текийг хүлээн авч уулзлаа.

Уулзалтын үеэр талууд Монголын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал болон цаашдын чиг хандлагын талаар мэдээлэл солилцсон төдийгүй Монгол Улсад хуримтлалын нэгдсэн сангийн тогтолцоог бий болгох, хөрөнгийн зах зээлээр дамжуулан тэтгэврийн тогтолцоог сайжруулах зэрэг асуудлаар санал солилцож, байр сууриа илэрхийлсэн юм.

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР ХӨРӨНГИЙН БИРЖИД АЙЛЧИЛЖ, АРИЛЖААГ НЭЭХ ХҮНДЭТГЭЛИЙН ЦАНГ ЦОХИЛОО

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр Монголын хөрөнгийн биржид ажиллан, хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал, цаашдын төлөвийн талаар санал солилцож 6803 дахь удаагийн үнэт цаасны арилжааг нээж цан цохилоо.

Ёслолын арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Дэд дарга Т.Цэрэнбадрал, Н.Хүдэрчулуун, Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал Х.Алтай, Бизнес хөгжлийн газрын захирал Т.Хаш-Эрдэнэ болон бусад хүндэт зочид оролцсон.

Монголын хөрөнгийн бирж нь 2021 онд дэлхийн хамгийн өндөр өсөлттэй хөрөнгийн биржээр тодорсон явдал нь эдийн засгийн агшилттай байгаа энэ хүнд цаг үед туйлын сайн мэдээ юм.



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН УДИРДЛАГУУД ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САНГИЙН ТӨЛӨӨЛӨЛТЭЙ УУЛЗАЖ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БОЛОН ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГЫН ТАЛААР САНАЛ СОЛИЛЦЛОО



2022 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр Монголын хөрөнгийн биржийн удирдлагууд Олон улсын валютын сангийн төлөөлөгч Сокхён Юүн болон эдийн засагч Силвия Иоргова нарыг хүлээн авч хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал болон зах зээлийн цаашдын чиг хандлагын талаар ярилцлаа. Тэр дундаа Банкны реформын хүрээнд хийгдэхээр төлөвлөж байгаа стратегийн нөлөө бүхий банкуудын олон нийтэд нээлттэй компани хэлбэрт шилжих асуудлаар санал солилцсон юм.

### МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ FTSE RUSSELL-ИЙН "FRONTIER MARKET" АНГИЛАЛД ОРУУЛАХЫГ ЗӨВШӨӨРЛӨӨ



Олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгааны чиглэлээр тэргүүлэгч Их Британийн FTSE Russell группээс 2022 оны 9-р сарын 29-ний өдөр

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтайд албан тоот ирүүлсэн. Уг албан тоотод Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг FTSE Russell-ийн "Хөгжиж буй" (Frontier Market) зах зээлийн зэрэглэлийн шалгуурыг бүрэн хангасан тул 2023 оны 9 дүгээр сараас эхлэн тус ангилалд оруулахыг зөвшөөрсөн тухай мэдэгдлээ.

Тус байгууллага нь мэргэжлийн хөрөнгө оруулагчийн зүгээс тавьдаг техникийн хэд хэдэн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу олон улсын зах зээлүүдийг "Хөгжиж буй"-гаас "Өндөр хөгжсөн" хүртэл үндсэн 4 зэрэглэлээр ангилдаг бөгөөд 2022 оны 9 дүгээр сарын байдлаар "Хөгжиж буй зах зээл"-ийн ангилалд Болгар, Эстони, Казахстан, Латви, Литва, Вьетнам зэрэг 29 улс багтаж байна.

МХБ нь өнгөрсөн хугацаанд дотоодын хөрөнгийн зах зээлийг олон улсын зах зээлийн зэрэглэлтэй болгох үүднээс төлбөр тооцооны системийг олон улсын

жишигт нийцүүлэх, олон улсын хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын таатай нөхцөл бүрдүүлэх чиглэлээр зах зээлийн зохицуулагч болон дэд бүтцийн байгууллагуудтай хамтран ажилласан.

Ийнхүү дотоодын зах зээлд гарч буй ахиц дэвшил, өөрчлөлтийн талаар FTSE Russell группд улирал тутамд танилцуулж ажилласны дүнд манай улсын зах зээлийг 2021 оны 9 дүгээр сард "Хөгжиж буй зах зээл"-ийн "Ажиглалтын жагсаалт"-нд оруулсан бол ийнхүү нэг жилийн дараа "Ажиглалтын жагсаалт"-наас "Хөгжиж буй зах зээл" ангилалд албан ёсоор оруулахыг зөвшөөрлөө.

Манай улсын хөрөнгийн зах зээлийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн энэхүү үйл явдал нь олон улсын хөрөнгө оруулалтыг татах, зах зээлийн арилжааны идэвх, хөрвөх чадварыг нэмэгдүүлж, хөгжлийг хурдасгах ач холбогдолтой юм.



## ЭКСПОРТОД ГАРГАХ НҮҮРСИЙГ МХБ-ЭЭР ДАМЖУУЛАН АРИЛЖИНА

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн ээлжит хуралдаанаар “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ыг баталсан.

Ингэснээр экспортын нүүрсний 30%-ийг 2023 оны 7 дугаар сарын 1 хүртэл МХБ-ээр дамжуулан ил тод, нээлттэй арилжаалж, арилжааны үйл ажиллагаанд Санхүүгийн Зохицуулах Хороо хяналт тавьж ажиллахаар зохицуулсан юм.



## БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИУД 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА НЭЭЛТТЭЙ ТАНИЛЦУУЛЛАА

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь бүртгэлтэй хувьцаат компаниудын мэдээллийн ил тод, нээлттэй байдал, үүргийн хэрэгжилт, компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг хангуулах зорилгоор МХБ-ийн бүртгэлтэй компаниудын хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг олон нийтэд нээлттэй илтгэл хэлбэрээр танилцуулах ажлыг 2022 оны 8 дугаар сарын 3-19-ний өдрүүдэд 7 дахь жилдээ уламжлал болгон зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд 1-р ангилалд бүртгэлтэй “Инвекор” ХК, “Монгол шуудан” ХК, “Говь” ХК, “Ард даатгал” ХК, “Ард кредит” ХК, “Би Ди Сек” ХК, “Ард санхүүгийн нэгдэл” ХК, “АПУ” ХК, “ЛэндМН ББСБ” ХК, “Мандал Даатгал” ХК, “Тавантолгой” ХК, “Мик Холдинг” ХК, “Сүү”, ХК, “Талх Чихэр” ХК, “Түмэн Шувуут” ХК “Монос Хүнс” ХК, “Бодь Даатгал” ХК, “Богд Банк” ХК, 2-р ангилалд бүртгэлтэй “Сэнтрал Экспресс Си Ви Эс” ХК, “Эрдэн Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК нийт 20 компаниуд оролцож, олон нийтэд үйл ажиллагаагаа танилцуулсан юм.

## НЭГ ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД ХОЁР ДАХЬ ЖИЛДЭЭ НЭГДЛЭЭ



Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангахад хувь нэмэр оруулах зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эхлүүлсэн.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн хамт олон 2021 онд тус хөдөлгөөнд нэгдэж Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 24-р хороонд мод тарин, байгууллагын нэрэмжит төгөл байгуулсан юм.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг амжилттай хэрэгжүүлснээр цөлжилтөд нэн хүчтэй өртсөн 129 га талбай 4 хувиар буурна, 2030 он гэхэд энэ үзүүлэлтийг 9 хувьд хүргэж, хүлэмжийн хийн ялгарлыг 600 мянган тонноор бууруулах урьдчилсан тооцоо гарсан билээ.

Монголын хөрөнгийн бирж 2022 онд экологийн тэнцвэрт байдлыг хангах, тэр дундаа цөлжилт болон ой модны нөөцийг нэмэгдүүлэхэд хөрөнгийн зах зээлийн оролцогч байгууллагуудаа уриалж хоёр дахь жилдээ мод тарьсан.

## ТӨРИЙН БАНК НИЙТ ХУВЬЦААНЫХАА 5 ХУВИЙГ ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОЛОО



“Төрийн банк” нь 2022 оны 9-р сард нийт хувьцааныхаа 5 хувь буюу 37,475,000 ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар нэг бүрийг нь 590 төгрөгөөр олон нийтэд санал болгож, 22.1 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр анхдагч зээлийн арилжаагаа зохион байгуулж, санал болгосон нийт үнэт цаасны 70 хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад, үлдэх 30 хувийг олон нийтэд хуваарилсан.

Тус банк нь олон нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн нийт захиалгыг ҮЦТХТ дахь мөнгөний үлдэгдэлтэй нийцүүлэхэд 7,306 хувь хүн, аж ахуйн нэгжээс нийт 67,356,571,200 төгрөгийн үнэт цаас худалдан авах санал ирүүлсэн нь татан төвлөрүүлэх дүнгээс 3 дахин давсан үзүүлэлт болсон юм.

## ГОЛОМТ БАНК НИЙТ ХУВЬЦААНЫХАА 10.09 ХУВИЙГ ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОЛОО

“Голомт банк” 2022 оны 11-р сарын 23-нд нийт хувьцааныхаа 10 хувь буюу 80,402,743 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 1,285 төгрөгөөр тогтоосон үнийн аргаар олон нийтэд санал болгож, 103.3 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулсан.

Тус банк нь нийт хувьцааныхаа 10.09% буюу 800 сая ширхэг хувьцааг, нэгжийн үнийг нь 1,285 төгрөгөөр олон нийтэд санал болгон 2022 оны 11-р сарын 23-наас 11-р сарын 30-ны өдрийн хооронд захиалга авсан юм.

Голомт Банк IPO хийснээр Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй компаниудын нийт зах зээлийн үнэлгээг 20 орчим хувиар буюу 1 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж, үнэлгээ нь нэг их наяд давсан хоёр дахь нээлттэй хувьцаат компани болоод байна.



## ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН

	Үнэт цаасны төрөл	Олон нийтэд санал болгосон дүн	Захиалгын дүн	Захиалгын хувь	Хөрөнгө оруулагчдын тоо
“МОН БИЙФ” ХК	Хувьцаа	₮ 2.90	₮ 6.60	228.00%	2,453
Омни актив ХБУЦ	ХБУЦ	₮ 5.00	₮ 5	100%	124
“СИМПЛ АССЕТ ТЭК” ХХК	ХБУЦ	₮ 50	₮ 50	100%	251
“БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЭК” ХХК	ХБУЦ	₮ 10	₮ 10	100%	159
“ТӨРИЙН БАНК” ХК	Хувьцаа	₮ 25.40	₮ 67.40	265%	7,306
“ГОЛОМТ БАНК” ХК	Хувьцаа	₮ 118.80	₮ 173.20	146%	21,281
“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК	Хувьцаа	₮ 11.90	₮ 57.90	486%	7,414
ЛэндМН актив ХБУЦ	ХБУЦ	₮ 4.80	₮ 4.80	100%	299
Нөмөр Кредит ассет ХБУЦ	ХБУЦ	₮ 10	₮ 10	100%	112
Бичил Глобус ХБУЦ	ХБУЦ	₮ 10	₮ 10	100%	160
“СЭНДЛИ ББСБ” ХК	Хувьцаа	₮ 10	₮ 11.60	116%	3,325
Эрдэнэс таван толгой	БОНД	₮ 76.60	₮ 76.60	100%	36
Лэнд Бонд	БОНД	₮ 3.10	₮ 3.10	100%	187
Инвекор Бонд	БОНД	₮ 20	₮ 20	100%	201
“Эрдэнэс Сольюшинс” ХК	НЭМЭЛТ ХУВЬЦАА	1.8	1.9	106%	1,256
Инвекор ББСБ ХК	НЭМЭЛТ ХУВЬЦАА	16.6	16.7	100%	526



## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

₮6.9

их наяд

+15%

+0.9

их наяд

### ТОП-20 ИНДЕКС

37,566

нэгж

-15%

-6,845

нэгж

### MSE A

14,137

нэгж

-9%

-1,345

нэгж

### MSE B

12,667

нэгж

+4%

+465

нэгж



# ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

## ХУВЬЦААНЫ БҮРТГЭЛ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д 2022 оны 12 сарын 31-ний байдлаар 183 ХК бүртгэлтэй байгаагаас 9% буюу 16 ХК нь 100 хувь төрийн өмчит, 5% буюу 11 ХК нь төрийн өмчийн оролцоотой, 86% буюу 156 ХК нь бүрэн хувьчлагдсан компани байна.

Уул уурхай	11
Хүнд үйлдвэрлэл	3
Ойн аж ахуй	2
Хөдөө аж ахуй	19
Хүнсний үйлдвэрлэл	17
Хөнгөн үйлдвэрлэл	11
Барилгын материал үйлдвэрлэл	12
Барилга, зам угсралт	14
Тээвэр	9
Нийтийн хангамж	16
Худалдаа	16
Үйлчилгээ	9
Хэвлэл мэдээлэл	1
Харилцаа холбоо	1
Санхүү	23
Үл хөдлөх хөрөнгө	12
Технологи	3


Бүртгэлтэй үнэт цаасны хувьд нийт 16.7 тэрбум ширхэг хувьцаа бүртгэлтэй байгаагаас 27,8% буюу 4.6 тэрбум ширхэг нь төрийн мэдлийн, 72,2% буюу 12.1 тэрбум ширхэг нь хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувьцаа байна.

## ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДИКАТОРУУД

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар МХБ-д бүртгэлтэй олон нийтэд хувьцаа нь арилжаалагдаж буй компаниудын нийт зах зээлийн үнэлгээ нь 6.89 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 909,26 тэрбум төгрөгөөр буюу 15.21 хувиар өссөн үзүүлэлтэй гарчээ.



12-р сарын 31-ний байдлаар ТОП-20 индекс 37,565 нэгж хүрсэн бөгөөд энэ нь 2021 оны мөн үетэй харьцуулахад 6,846 нэгжээр буюу 15.42% хувиар буурсан үзүүлэлттэй байна.



Мөн тайлант хугацаанд MSE A индекс 14,137 нэгж хүрсэн өмнөх оны мөн үеэс 1344 нэгжээр буюу 8.69%-ийн бууралттай байгаа бол MSE B индекс 12,667 нэгжид хүрч энэ нь мөн өмнөх онтой харьцуулахад 464 нэгжээр буюу 3.81%-иар өссөн үзүүлэлттэй байна.

## ТОП-20 ИНДЕКСИЙН САГС

Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журмын дагуу үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлогч гол үзүүлэлт болох ТОП-20 индексийн сагсыг 2022 онд дараах компаниуд бүрдүүлж байв.

	СИМБОЛ	ҮНЭТ ЦААСНЫ НЭР
1	APU	АПУ ХК
2	AARD	Ард Санхүүгийн Нэгдэл ХК
3	GOV	Говь ХК
4	ERDN	Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК
5	INV	Инвескор ББСБ ХК
6	TTL	Таван Толгой ХК
7	TUM	Түмэн Шувуут ХК
8	ADB	Ард Кредит ББСБ ХК
9	MNDL	Мандал Даатгал ХК
10	UID	Улсын Их Дэлгүүр ХК
11	AIC	Ард Даатгал ХК
12	SUU	Сүү ХК
13	MFC	Монос Хүнс ХК
14	MNP	Монгол Шуудан ХК
15	LEND	ЛэндМн ББСБ ХК
16	BODI	Бодь Даатгал ХК
17	NEH	Дархан Нэхий ХК
18	MMX	Мах Импекс ХК
19	BDS	Би Ди Сек ХК
20	TCK	Талх чихэр ХК

## ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

2022 онд нийт 246 удаагийн үнэт цаасны арилжаа явагдаж, анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 154 ХК-ийн 592,42 сая ширхэг хувьцааг 343.36 тэрбум төгрөгөөр 0.99 сая ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг 98.93 тэрбум төгрөгөөр, 8.95 сая ширхэг нэгж эрхийг 4.17 тэрбум төгрөгөөр, 1.25 сая ширхэг компанийн бондыг 134.06 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн байна.



Нийт арилжааны үнийн дүнгийн 59.15 хувь буюу 343.35 тэрбум төгрөгийг хувьцааны арилжаа, 17.04 хувь буюу 98.93 тэрбум төгрөгийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа, 0.72 хувь буюу 4.16 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа, 23.09 хувь буюу 134.06 тэрбум төгрөгийг компанийн бондын арилжаа тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд өдөрт дунджаар 2.5 сая ширхэг үнэт цаасыг 2.4 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

## ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

Тайлант хугацаанд нийт 246 удаагийн арилжаагаар 154 ХК-ийн 592.42 сая ширхэг хувьцааг 343.36 тэрбум төгрөгөөр арилжсан ба 51.20 хувь буюу 175.78 тэрбум төгрөгийн гүйлгээг анхдагч зах зээлийн арилжаа, 48.80 хувь буюу 167.56 тэрбум төгрөгийн гүйлгээг хоёрдогч зах зээлийн арилжаа эзэлж байна.



## АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Хувьцааны анхдагч зах зээлд нийт 288.56 сая ширхэг буюу 175.78 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хувьцааг олон нийтэд санал болгон амжилттай арилсан ба энэ нь нийт хувьцааны арилжааны 51.20 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 дахин өссөн үзүүлэлт юм.

## ХУВЬЦААНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны үнийн дүнгийн 42.3 хувь буюу 70.88 тэрбум төгрөгийн гүйлгээг багцын арилжаа, 48.7 хувь буюу 81.6 тэрбум төгрөгийн гүйлгээг энгийн арилжаа, 0.15 хувь буюу 0.25 тэрбум төгрөгийн гүйлгээг бүгдийг нь биелүүлэх эсвэл үл биелүүлэх дуудлага арилжаа /AON/, 8.85 хувь буюу 14.83 тэрбум төгрөгийн гүйлгээг тендер арилжаа тус тус эзлэж байна.



## ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

Тайлант хугацаанд хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны анхдагч зах зээлд нийт 850 мянган ширхэг, 85 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг амжилттай арилжсан байна. Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 139.3 мянган ширхэг үнэт цаасыг 13.93 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН

Тайлан хугацаанд "Үндэсний хувьчлалын сан" болон "Мандал ирээдүйн өсөлт" хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 8.95 сая ширхэг нэгж эрхийг 4.16 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

## БАГЦЫН АРИЛЖАА

Тайлант хугацаанд нийт 22 хувьцаат компанийн 84.12 сая ширхэг буюу 70.88 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий багцын арилжаа хийгдсэн нь хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 42.3 хувийг эзэлж байна. Үүнд өндөр дүнгээр арилжаалагдсан эхний гурван хувьцаат компани нь "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК, "Ард Даатгал" ХК, "АПУ" ХК байна.

## КОМПАНИЙН БОНД

Тайлант хугацаанд компанийн бондын анхдагч зах зээлд нийт 997.1 мянган ширхэг, 99.71 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий ерийн хэрэгсэл арилжигдсан байна. Үүнд:

- "Эрдэнэс таван толгой" ХК-ийн нэг бүр нь 100,000 төгрөгийн үнэтэй, жилийн 10 хувийн хүүтэй, 2-3 жилийн хугацаатай нийт 5.4 сая ширхэг төгрөгийн бондыг 543.42 тэрбум төгрөгөөр, нэг бүр нь 100 ам.долларын үнэтэй, жилийн 5.8-6.8 хувийн хүүтэй, 2 жилийн хугацаатай нийт 523.3 мянган ширхэг ам.долларын бондыг 149.1 тэрбум төгрөгөөр тус тус олон нийтэд санал болгож, нийт 5.95 сая ширхэг, 692.55 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий бондыг амжилттай арилжсан.
- "Инвекор ББСБ" ХК-ийн нэг бүр нь 100,000 төгрөгийн үнэтэй, жилийн 13 хувийн хүүтэй, 2 жилийн хугацаатай 200 мянган ширхэг "Инвекор бонд"-ыг нийт 20 тэрбум төгрөгөөр анхдагч зах зээлд арилжсан байна.
- "ЛэндМН ББСБ" ХК-ийн 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, хоёр жилийн хугацаатай, жилийн 13-14 хувийн хүүтэй, 75 мянган ширхэг, нийт 7.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий "Лэндбонд" анхдагч зах зээлд амжилттай тус тус арилжигдсан байна.

Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 3.2 сая ширхэг бондыг 328.1 тэрбум төгрөгөөр арилжааллаа.

## БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУД

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар I ангилалд 23, II ангилалд 45, III ангилалд 115 хувьцаат компани багтаж байна.



**ИДЭВХТЭЙ АРИЛЖИГДСАН 30 ҮНЭТ ЦААС**

ҮНЭТ ЦААС	ШИРХЭГ /сая/	ҮНЭТ ЦААС	ҮНИЙН ДҮН /тэрбум/
АПУ	43.80	АПУ	64.22
Экспресс Си Ви Эс	38.07	Ард Санхүүгийн Нэгдэл	23.12
Монос Хүнс	28.23	Хөсөг Трейд	14.26
Монбийф	25.70	Сэнтрал Экспресс Си Ви Эс	7.52
Мандал Даатгал	23.90	Голомт Банк	6.36
Тандэм Инвэст ББСБ	14.81	Инвескор ББС	4.43
Бодь Даалтгал	12.03	Түмэн Шувуут	3.80
Хот Девелопмент	11.29	Таван Толгой	3.69
Ард Кредит ББСБ ХК	9.97	Монгол Шуудан ХК	3.56
Дархан Нэхий	9.26	Мандал Ирээдүйн Өсөлт	3.47
ЛэндМн ББСБ	8.58	Монос Хүнс	3.36
Түмэн Шувуут	7.79	Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн	2.85
Говь	7.55	Талх Чихэр	2.81
Ремикон	5.86	Мандал Даатгал	2.48
Монгол Шуудан ХК	5.21	Ард Даатгал ХК	2.42
Үндэсний Хувьчлалын Сан	5.12	Говь	2.10
Голомт Банк	5.09	Улсын Их Дэлгүүр	1.94
Женко Тур Бюро	4.95	Бодь Даатгал	1.79
Монинжбар	4.45	Төрийн Банк	1.71
Мандал Ирээдүйн Өсөлт	3.83	Крипто Үндэстэн	1.71
Ард Санхүүгийн Нэгдэл	3.79	Баянгол Зочид буудал	1.38
Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК	3.34	Ард Кредит ББСБ ХК	1.26
Сэндли БСББ	3.32	Монбийф	1.16
Эрдэнэс Сольюшинс	2.73	Богд Банк	1.07
Ард Даатгал ХК	2.58	Сүү	0.70
Булигаар	2.39	Үндэсний Хувьчлалын Сан	0.69
Гермес Центр	2.17	Хот Девелопмент	0.68
Төрийн Банк	2.12	Тэнгэрлиг Медиа Групп ХК	0.61
Шарын Гол Монгол Базальт	1.83	Сэндли БСББ	0.56
Хөх Ган	1.79	Монинжбар	0.48

**ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ 20 ҮНЭТ ЦААС**

ҮНЭТ ЦААС	2021.12.31	2022.12.30	НЭГЖ	ХУВЬ
Хүрд	4,279.00	45,720.00	41,441.00	968.47
Тээвэр-Ачлал	2,125.00	10,920.00	8,795.00	413.88
Монгол Дизель	825.89	3,333.00	2,507.00	303.56
Монноос	4,850.00	19,150.00	14,300.00	294.85
Хорин Хоёрдугаар Бааз	730.00	2,733.00	2,003.00	274.38
Хөвсгөл Усан Зам	1,679.00	6,250.00	4,571.00	272.25
Гутал	25,300.00	55,050.00	29,750.00	117.59
Шинэст	115.00	201.12	86.12	74.89
Хүннү Менежмент	856.00	1,445.00	589.00	68.81
Бэрх Уул	1,000.00	1,587.00	587.00	58.70
Мандал Говь Импекс	450.00	710.00	260.00	57.78
Хөсөг Трейд	3,919.00	5,955.00	2,036.00	51.95
Монгол Нэхмэл	3,500.00	5,060.00	1,560.00	44.57
Эрчим Баян Өлгий	2,379.00	3,300.00	921.00	38.71
Мик Холдинг	14,990.00	20,260.00	5,270.00	35.16
Дархан Хөвөн	7,500.00	10,050.00	2,550.00	34.00
Дэвшил Мандал	110.00	146.05	36.05	32.77
Асби	531.30	702.63	171.33	32.25
Тавилга	1,825.00	2,412.00	587.00	32.16
Хар Тарвагатай	4,000.00	5,230.00	1,230.00	30.75

**ХАНШИЙН БУУРАЛТТАЙ 20 ҮНЭТ ЦААС**

ҮНЭТ ЦААС	2021.12.31	2022.12.30	НЭГЖ	ХУВЬ
Монгол Керамик	15,200.00	1,110.00	(14,090.00)	(92.70)
Евроази Капитал Холдинг	985.00	165.00	(820.00)	(83.25)
Өндөрхаан	10,100.00	2,600.00	(7,500.00)	(74.26)
Дархан Зочид Буудал	230.00	72.00	(158.00)	(68.70)
Сэлэнгэ Сүрэг	4,269.00	1,420.00	(2,849.00)	(66.74)
Эрээнцав	3,890.00	1,400.00	(2,490.00)	(64.01)
Хасу-Мандал	6,000.00	2,600.00	(3,400.00)	(56.67)
Жуулчин Говь	8,000.00	3,500.00	(4,500.00)	(56.25)
Силикат	44.67	20.00	(24.67)	(55.23)
Глобал Монголиа Холдинг	510.00	230.00	(280.00)	(54.90)
УБ-БҮК	770.00	380.10	(389.90)	(50.64)
Ард Санхүүгийн Нэгдэл	9,785.00	4,880.00	(4,905.00)	(50.13)
Монголын Хөгжил Үндэсний Нэгдэл ХК	2,800.00	1,400.00	(1,400.00)	(50.00)
Монгол Шевро	2,560.00	1,300.00	(1,260.00)	(49.22)
Хэрлэн Хивс	120.00	61.00	(59.00)	(49.17)
Гонир	900.00	460.00	(440.00)	(48.89)
Түмэн Шувуут	676.13	350.46	(325.67)	(48.17)
Эрдэнэс Сольюшинс	85.99	44.84	(41.15)	(47.85)
Монгео	12,400.00	6,500.00	(5,900.00)	(47.58)
Крипто Үндэстэн	164,900.00	90,720.00	(74,180.00)	(44.98)

# САНХҮҮГИЙН ТАЙЛАН

# 2022



МОНГОЛЫН  
ХӨРӨНГИЙН БИРЖ





## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

### МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК-ИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/49/НА-СТА-ТӨААТҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: П.Чанцалдулам  
Утас: 261885 Цахим хаяг: [chantsaldulamp@audit.gov.mn](mailto:chantsaldulamp@audit.gov.mn)  
Аудитор: С.Алтанхуяг  
Утас: 261628 Цахим хаяг: [altankhuyags@audit.gov.mn](mailto:altankhuyags@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит"  
ХХК-ийн захирал: Ц.Бямбажав  
Утас: 70130460 Цахим хаяг: [auditulziit@gmail.com](mailto:auditulziit@gmail.com)



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2023.03.21 № 07/616  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ”  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Х.АЛТАЙ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон зорилтот түвшний гүйцэтгэлд аудит хийлээ.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус компани нь нийт хувьцааныхаа 34 хувийг олон нийтэд санал болгосон бөгөөд 2022 оны 12 сарын 26-наас 12 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хувьцаа худалдах санал хүлээн авсан байна.

### Аудитын гол асуудал

УИХ-ын 2022 оны 16 дугаар тогтоолоор Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-ын хувьцааг олон нийтэд нээлттэй худалдах шийдвэрийн хүрээнд ТУЗ-ийн 2022 оны 19 дүгээр тогтоол, ТӨБЗГ-ын 505 дугаар хөрөнгийг дахин үнэлэх тогтоолын дагуу барилга, байгууламжийг 4,925.0 сая төгрөг, тээврийн хэрэгслийг 7.3 сая төгрөг, машин тоног төхөөрөмжийг 529.6 сая төгрөг, тавилга эд хогшил 118.7 сая төгрөг, биет бус хөрөнгө болон газрыг 17,895.5 сая төгрөг нийт 23,476.3 сая төгрөгөөр үнэлж тайлант онд тайлагнасан байна.

### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*B. N.*

Ц.НАРАНЧИМЭГ





**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН** (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	12/31/2021	12/31/2022
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	2,729,363,635.92	1,731,709,823.19
1.1.2	Дансны авлага	97,240,920.31	504,659,308.86
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	18,336.58	822,948.07
1.1.4	Бараа материал	26,570,837.69	33,650,495.17
1.1.5	Урьдчилж төлсөн зардал тооцоо	7,666,370.89	12,775,744.36
1.1.6	Бусад эргэлтийн хөрөнгө	13,160,000.00	13,160,000.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,874,020,101.40</b>	<b>2,296,778,319.65</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,121,771,489.56	5,536,483,495.32
1.2.2	Биет бус хөрөнгө	382,782,168.52	17,648,438,922.94
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,504,553,658.08</b>	<b>23,184,922,418.26</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,378,573,759.48</b>	<b>25,481,700,737.91</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	720,558,353.30	793,176,221.30
2.1.1.2	Татварын өр	206,262,926.45	190,085,198.35
2.1.1.3	Урьдчилж орсон орлого	14,247,509.45	15,396,128.31
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>941,068,789.20</b>	<b>998,657,547.96</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Хойшлогдсон татварын өр		990,846,139.66
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>990,846,139.66</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>941,068,789.20</b>	<b>1,989,503,687.62</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - Төрийн	23,130,593,600.00	23,130,593,600.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	12,362,216.67	20,021,146,332.29
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	446,321,902.02	446,321,902.02
2.3.9	Хуримтлагдсан ашиг	- 19,151,772,748.41	- 20,105,864,784.03
2.3.9.1	Хуримтлагдсан ашиг/ өмнөх үеийн /	- 22,336,322,387.40	- 20,752,093,007.67
2.3.9.2	Хуримтлагдсан ашиг /тайлант үеийн /	3,184,549,638.99	646,228,223.64
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>4,437,504,970.28</b>	<b>23,492,197,050.28</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>5,378,573,759.48</b>	<b>25,481,700,737.91</b>

## ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (төгрөгөөр)

Үзүүлэлт	12/31/2021	12/31/2022
<b>1 Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>5,483,078,582.38</b>	<b>4,241,344,850.62</b>
2 Борлуулалтын өртөг		
<b>3 Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>5,501,624,362.55</b>	<b>4,241,344,850.62</b>
4 Хүүгийн орлого	19,301,917.80	-
5 Бусад орлого	18,545,780.17	27,070,762.46
6 Ерөнхий ба удирдлагын зардал	2,136,265,973.93	3,557,629,057.47
7 Бусад зардал	30,363,052.75	71,765,222.02
8 Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )	57,525.18	130,867,477.80
9 Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	(1,619,200.00)	(141,003.17)
<b>10 Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал )</b>	<b>3,352,735,578.87</b>	<b>769,747,808.20</b>
11 Орлогын татварын зардал	168,185,939.88	123,519,584.56
<b>12 Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>3,184,549,638.99</b>	<b>646,228,223.64</b>
13 Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )		
<b>14 Бусад дэлгэрэнгүй орлого</b>		<b>20,008,784,115.62</b>
15 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү		20,008,784,115.62
16 Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
17 Бусад олз ( гарз )		
<b>18 Орлогын нийт дүн</b>	<b>3,184,549,638.99</b>	<b>20,655,012,339.26</b>



## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН (төгрөгөөр)

Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2021 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл</b>	<b>23,130,593,600.00</b>	<b>12,362,216.67</b>	<b>446,321,902.02</b>	<b>(22,336,322,387.40)</b>	<b>1,252,955,331.29</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				3,184,549,638.99	<b>3,184,549,638.99</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>23,130,593,600.00</b>	<b>12,362,216.67</b>	<b>446,321,902.02</b>	<b>(19,151,772,748.41)</b>	<b>4,437,504,970.28</b>
<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>				-	-
<b>2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>23,130,593,600.00</b>	<b>12,362,216.67</b>	<b>446,321,902.02</b>	<b>(19,151,772,748.41)</b>	<b>4,437,504,970.28</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-1,600,320,259.26	<b>(1,600,320,259.26)</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>23,130,593,600.00</b>	<b>12,362,216.67</b>	<b>446,321,902.02</b>	<b>(20,752,093,007.67)</b>	<b>2,837,184,711.02</b>
<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>				<b>646,228,223.64</b>	<b>646,228,223.64</b>
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		20,008,784,115.62			<b>20,008,784,115.62</b>
<b>2022 оны 12-р сарын 31-рх үлдэгдэл</b>	<b>23,130,593,600.00</b>	<b>20,021,146,332.29</b>	<b>446,321,902.02</b>	<b>(20,105,864,784.03)</b>	<b>23,492,197,050.28</b>

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (төгрөг)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	12/31/2021	12/31/2022
1	<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	0.0	0.0
1.1	<b>Мөнгөн орлогын дүн(+)</b>	5,699,769.9	3,914,481.2
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,951,952.4	3,735,454.9
1.1.2	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	10,896.1	1,684.8
1.1.3	Бусад мөнгөн орлого	736,921.4	177,341.5
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	3,427,313.6	4,619,870.4
1.2.1	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.0	0.0
1.2.2	Ажиллагчдад төлсөн	585,159.4	876,401.7
1.2.3	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	182,327.8	259,137.5
1.2.4	Бараа материал худалдан авахад төлсөн	23,291.5	35,755.8
1.2.5	Ашиглалтын зардалд төлсөн	46,951.5	65,253.7
1.2.6	<b>Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн</b>	8,120.7	7,674.5
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	348,440.8	473,654.1
1.2.8	<b>Даатгалын төлбөрт төлсөн</b>	0.0	0.0
1.2.9	<b>Бусад мөнгөн зарлага</b>	2,233,021.9	2,901,993.1
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	2,272,456.3	(705,389.2)
2	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	0.0	0.0
2.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	19,301.9	0.0
2.1.1	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	19,301.9	0.0
2.1.2	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.0	0.0
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	116,984.4	423,392.5
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	116,984.4	286,663.7
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.0	136,728.8
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	(97,682.5)	(423,392.5)
3	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	0.0	0.0
3.1	<b>Мөнгөн орлогын дүн(+)</b>	0.0	0.0
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.0	0.0
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн(-)</b>	0.0	0.0
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.0	0.0
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.0	0.0
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	0.0	0.0
4	Валютын ханшийн зөрүү	0.0	131,127.9
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	2,174,773.8	(997,653.8)
6	<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>	554,589.8	2,729,363.6
7	<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	2,729,363.6	1,731,709.8



МОНГОЛЫН  
ХӨРӨНГИЙН БИРЖ

Монголын Хөрөнгийн Бирж

**Хаяг:** Сүхбаатарын талбай-3,  
Улаанбаатар 15160, Монгол улс

**Утас:** (+976)-11-313747

**Факс:** (+976)-11-325170

**Веб хуудас:** [www.mse.mn](http://www.mse.mn)

**И-мэйл:** [info@mse.mn](mailto:info@mse.mn)